

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 24 оны 02 сарын 19 өдөр

№ R-2024-02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 болон 46.5 дахь хэсэг, ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалт болон Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

## ТЭМДЭГЛЭХ нь:

- Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 болон 46.8 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ нь татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх талаар санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэх шаардлагатай болохыг;
- Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
- Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2023 оны санхүүгийн жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (“Ногдол ашиг”)-ыг ТУЗ-д санал болгосныг;
- Хуваарилах ногдол ашгийн хэмжээ нь 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан гарсны дараа бүрэн тодорхойлогдох боломжтой болохыг; мөн
- ТУЗ нь 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан, Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

## ТОГТООХ нь:

- Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүнгээс шалтгаалан Ногдол ашигт нийт 26,580,675,000.00 (хорин зургаан тэрбум таван зуун наян сая зургаан зуун далан таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 25.25 (хорин таван төгрөг хорин таван мөнгө) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
- Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

3. Хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойших 7 хоногоос хэтрүүлэлгүйгээр ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлж эхэлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

A large, stylized black ink signature.

Н.МӨНХЦЭЛМЭГ